

“МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН  
ЧИГЛЭЛ”-ИЙН ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗАРТ ХОЛБОГДОХ  
АРГА ХЭМЖЭЭНИЙ 2023 ОНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-  
ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 18

Улаанбаатар хот

“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн байгууллагад хамаарах арга хэмжээний 2023 оны хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/107 дугаар тушаалаар баталсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах 3 арга хэмжээний хэрэгжилт 100 хувь буюу 5 оноотой дүгнэгдсэн байна. Үүнд:

**Арга хэмжээ 1:** Гадаадын иргэн, харьяалалгүй хүн, цагаачдын тооны зохист түвшнийг хадгалах, хяналт тавих тогтолцоог бэхжүүлнэ.

**Хэрэгжилт:** Монгол Улсад 2000-2004, 2005-2008, 2009-2012 онд оруулж болох цагаач гадаадын иргэдийн тоо, бүтэц, байршлын тухай Монгол Улсын Их Хурлын 2001 оны 96, 2005 оны 29, 2009 оны 44 дүгээр тогтоолд жилд оруулж болох цагаач гадаадын иргэний тоог жил бүр 100-аас дээшгүй байхаар тус тус тогтоож байсан. Монгол Улсад 2013-2016 онд оруулж болох цагаач гадаадын иргэдийн тоо, бүтэц, байршлыг тогтоолгохоор 2013, 2015 онд тус тус Засгийн газраас Улсын Их Хуралд тогтоолын төслийг танилцуулж байсан ч батлагдаагүй. Мөн Монгол Улсад 2017-2020 онд оруулж болох цагаач гадаадын иргэдийн тоо, бүтэц, байршлын тухай тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн барьж 2018 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн чуулганаар хэлэлцүүлэхэд дэмжигдээгүй болно. Иймд “Монгол Улсад 2021-2024 онд цагаачлуулж болох гадаадын иргэдийн тоо, бүтэц, байршлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг холбогдох танилцуулгын хамт 2023 оны 11 дүгээр

сарын 30-ны өдрийн 01/2075 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүллээ. 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 1836 гадаадын иргэн Монгол Улсад цагаачлан оршин суухаар бүртгэлтэй байгаа нь нийт хүн амтай харьцуулахад 0.053 хувь, үүнээс хамгийн их буюу Бүгд Найрамдах Хятад Ард Улсын иргэн 1224 байгаа нь 0.035 хувь буюу Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсэгт заасан хэмжээнээс хэтрээгүй байна. /100 хувь/

**Арга хэмжээ 2:** Гадаадын иргэдийг улсын хилээр нэвтрэх үед биеийн давхцахгүй өгөгдлийг авч, нэгдсэн санд бүртгэх тогтолцоог бүрдүүлнэ.

**Хэрэгжилт:** “Гадаадын иргэний бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” системийг нэвтрүүлэх арга хэмжээг Хууль зүй, дотоод хэргийн сайдын улсын төсвийн хөрөнгө оруулалтын “Тоног төхөөрөмж” багцаас 470.0 сая төгрөгийг гүйцэтгэлийн дагуу санхүүжүүлэхээр 2022 онд төлөвлөн тус яамны Төрийн нарийн бичгийн даргын зөвшөөрлөөр гүйцэтгэгч байгууллагатай 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр “нууц” гэрээ байгуулсан. Гэрээний хэрэгжилтийг үндэслэн ажлын даалгаврын дагуу программ хангамжийг хүлээн авснаар 2022 онд санхүүжилтийг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 100 хувь гүйцэтгэгчид олгосон. “Гадаадын иргэний бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем” (ISM) (одоо ашиглаж байгаа хуучин систем) дэх визийн зөвшөөрөл, виз, оршин суух зөвшөөрөл, гадаадын иргэний бүртгэл хэсгийн үйлчилгээг “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” (ISF) системд 10 дугаар сарын 30-ны өдрөөс бүрэн нэвтрүүлж, хүсэлтийг хүлээн авч эхэлсэнтэй холбогдуулан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тоон гарын үсгийн хэрэглээг жигдрүүлэх, шинэ систем ашиглах боломж олгох зорилгоор дээрх цахим үйлчилгээг 12 дугаар сарын 11-ний өдрөөс isf.mn системээр үзүүлж эхэллээ. Цахим хөгжил, харилцаа холбооны яам, И-Монгол академитай хамтран 11 дүгээр сарын 02-ны өдрөөс танилт нэвтрэлтийн ДАН системд гадаадын иргэний бүртгэл (F-Register) ашиглан нэвтрэх үйлчилгээг “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” (ISF) системтэй холбосон.

Санхүүжилтийг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас шийдвэрлэсэн тул байгууллагаас тайлагнах боломжгүй бөгөөд 2023 онд хөгжүүлэлтэд төсөв зарцуулаагүй. /100 хувь/

**Арга хэмжээ 3:** Хууль сахиулах байгууллагууд иргэдийн өргөдөл, гомдлыг шуурхай хянан шийдвэрлэх, түүнд хяналт тавих цахим нэгдсэн сүлжээнд бүрэн холбогдож, иргэдэд үйлчлэх таатай орчныг бүрдүүлнэ.

**Хэрэгжилт:** Хууль зүй, дотоод хэргийн салбарын архив, албан хэрэг хөтлөлтийн “edoc” программыг нэвтрүүлсэнтэй холбогдуулан төв, орон нутаг дахь нэгжийн нийт 258 албан хаагчийг системд бүртгэн уг системийн “Өргөдөл” цэсийг байгууллагын үйл ажиллагаанд бүрэн ашиглаж, шийдвэрлэлтийг хянаж байна. /100 хувь/

#### Дүгнэлт, зөвлөмж

2023 онд байгууллагад хамаарах 3 арга хэмжээний хэрэгжилт 100 хувь буюу 5 оноотой дүгнэгдлээ.

Иймд цаашид нийт арга хэмжээний хэрэгжилтийн үр дүнг бууруулахгүйгээр чанаржуулж ажиллах;

Монгол Улсад хувийн хэргээр болон цагаачлан оршин суугч гадаадын иргэн, харьяалалгүй хүний Монгол Улсын харьяат хүн амын тоонд эзлэх хувийг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 27.4, 29.5 дахь хэсэгт заасан зохист хэмжээнд хадгалахад онцгой анхаарч ажиллахыг зөвлөмж болгож байна.

--oo0oo--